



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/145

Мандалговь

Зөвшөөрөл олгох тухай

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1, 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 13 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн ТУШААХ нь:

1. Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг Хөөтийн хонхор-2 “Биг могул коул энд энерги” ХХК-ний хүн амын унд ахуйн хэрэгцээнд 5868 шоо метр, Ногоон байгууламж, зам талбайн усалгааны зориулалтаар 31104 м³/жил усыг 1 жилийн хугацаагаар ашиглахыг “Биг могул коул энд энерги” ХХК-д зөвшөөрсүгэй.

2. “Биг могул коул энд энерги” ХХК-ний ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж, ажиллахыг усны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Цэрэнсугир)-т үүрэг болгосугай.

3. Монгол Улсын “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.20-д заасны дагуу ус ашиглах зөвшөөрлийн хураамжийг Баянжаргалан сумын Төрийн сан банкны дансанд тушаах, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.5-д заасны дагуу үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөрийг Дундговь аймгийн төсөвт гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлэхийг “Биг могул коул энд энерги” ХХК-ний захирал (Б.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

4. Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалтын дагуу ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны ашиглах боломжит нөөцийн хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэхгүй байх болон Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг “Биг могул коул энд энерги” ХХК-ний захирал (Б.Отгонбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Н.ГАНТУЛГА



Tuhsaal A

482301070